



**БАЯНГОЛ, ХАН-УУЛ, СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН
ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 2026/ШЗТ/02

Улаанбаатар хот

**"Нарийвчилсан журам"-д нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр,

Тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд,

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн 19.2.5, 19.8 дахь хэсэг, Шүүгчдийн зөвлөгөөний дэгийн 8 дахь хэсгийн 8.10 дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нарийвчилсан журам" /цаашид нарийвчилсан журам гэх/-ын 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 2.7, 2.8 гэсэн заалт, 8 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 8.3 гэсэн заалтыг тус тус нэмсүгэй.

1/2.7 дахь заалт:

2.7. Шинээр томилогдсон, шилжин томилогдож ирсэн, сэлгэн ажилласан, хүндэтгэн үзэх шалтгаанаар удаан хугацаагаар /энэ журмын 3.1-д зааснаар ойлгоно/ эзгүй байсан шүүгчид прокуророос шинээр ирсэн хэрэг хуваарилах, ийнхүү хуваарилалт хийхэд нэг шүүгчид ноогдох шийдвэрлэгдээгүй байгаа дундаж хэргийн тоотой тэнцүү тооны хэрэг хуваарилах, зогсоох асуудлыг Нийтлэг журмын 1.2-т заасан зарчмыг баримтлан тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

1/2.8 дахь заалт:

"2.8. Интернэт сүлжээний доголдол, тасалдлаас шалтгаалан "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем" ажиллаагүй үед хэргийг хуваарилахдаа гараар хуваарилахгүй ба ирсэн огнооны дарааллыг баримтлан системд нөхөн бүртгэж зөвхөн системээс хуваарилах бөгөөд энэ тохиолдолд үйлдэл тус бүрийг дүрс бичлэг хийж хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгална.

1/8.3 дахь заалт:

"8.3. Нарийвчилсан журмыг "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-д тохируулахдаа шүүхийн Тамгын газрын дарга,

000000066

хэргийн хөдөлгөөний чиг үүрэг хариуцсан удирдах ажилтан, Ерөнхий шүүгчийн туслах нарын хяналтын дор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулна.

2. Нарийвчилсан журмын 2 дахь хэсгийн дугаарлалтын “2.7” гэснийг “2.9” гэж, “2.8” гэснийг “2.10” гэж, “8.3” гэснийг “8.4” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Нарийвчилсан журмын 6 дахь хэсгийн заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

3/6.1 дэх заалт:

“6.1. Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөх үндэслэл болохгүй бөгөөд бүрэлдэхүүнд томилогдсон Ерөнхий шүүгч, шүүгч нь удаан хугацаагаар эзгүй байгаа, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдаж байгаа, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй тохиолдолд хурал давхцаагүй өөр шүүгчийг тойрог дотор болон өөр тойргоос санамсаргүй тохиолдлын аргаар “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-ээс томилно.

3/6.2 дахь заалт:

“6.2. Энэ журмын 6.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүх бүрэлдэхүүний шүүгчийг өөрчлөхгүй, өөр тойргийн багцаас шүүгч бүрэлдэхүүнд томилохыг хориглоно.”

4. Нарийвчилсан журмын 2.2, 2.5, дахь заалтын “Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем” гэснийг, 2.6, 2.10, 3.1 дэх заалтын “нэгдсэн систем” гэснийг “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем” гэж тус тус өөрчилсүгэй.

5. “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-д өмнөх тойргийн мэдээллийг цааш авч үргэлжлүүлэн ашигласугай.

6. Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Б.ДАШДОНДОВ

ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ,
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР
ТОМИЛОХ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн хэрэг хүлээн авах, хуваарилах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбогдуулж гаргасан хэргийн оролцогчийн хүсэлт, гомдол, прокурорын санал, дүгнэлтийг хуваарилахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсанаар ойлгоно.

1.2.1. “Хэрэг” гэдгийг Нийтлэг журмын 1.3 дахь хэсгийн 1.3.1-д зааснаар,

1.2.2. “Өргөдөл, гомдол, хүсэлт” гэдгийг Нийтлэг журмын 1.3 дахь хэсгийн 1.3.3-т зааснаар.

Хоёр: Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох дарааллыг сугалаагаар тогтоох

2.1. Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт, прокурорын дүгнэлт, санал хүлээн авах, хуваарилахад Нийт шүүгчийн чуулганы 2021 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 1 дэх хэсгийн 1.2-т заасан үндсэн зарчмуудыг баримтална.

2.2. Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч шийдвэрлэх шүүгч нарыг нэг тойрог болгож нэрсийг сугалсан сугалааны дугаараар жагсааж “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-д байршуулна. Үүнд:

1. А.Алтанхуяг
2. Ц.Эрдэнэчимэг
3. Ц.Амар
4. Г.Золбоо
5. Б.Наранжаргал
6. Л.Баатар
7. Д.Доржсүрэн
8. Д.Алтанжигүүр
9. Г.Энхцэцэг
10. Н.Нямдаваа
11. И.Ганбат
12. Ц.Дайрийжав
13. Б.Дашдондов
14. Ч.Отгонбаяр
15. М.Далайхүү
16. Х.Одбаяр
17. Г.Алтанцэцэг
18. Б.Булгантамир
19. М.Мөнхбаатар

/Энэ заалтад 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 13 дугаар тогтоолоор өөрчилсөн/

/Энэ заалтад 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 15 дугаар тогтоолоор өөрчилсөн/

/Энэ заалтад 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 17 дугаар тогтоолоор өөрчилсөн/

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 01, 02 дугаар тогтоолуудаар нэмэлт, өөрчлөлт

оруулсан/

2.3. Шүүх бүрэлдэхүүнээр хэрэг хянан шийдвэрлэх хэрэгт шүүгч нарыг “А”, “Б”, “В”, “Г” гэсэн тойрог үүсгэж, бүрэлдэхүүнийг дараах байдлаар тогтоох.

“А” тойрог:

1. М.Далайхүү
2. Д.Доржсүрэн
3. ~~О.Жанчивнямбуу~~
4. Г.Золбоо
5. Ц.Эрдэнэчимэг
6. Б.Наранжаргал

А заал

“Б” тойрог:

1. Г.Алтанцэцэг
2. Ц.Амар
3. Б.Булгантамир
4. Б.Дашдондов
5. М.Мөнхбаатар
6. Г.Энхцэцэг

Б заал

“В” тойрог:

1. А.Алтанхуяг
2. Ц.Дайрийжав
3. ~~Ц.Мөнх-Эрдэнэ~~
4. Н.Нямдаваа
5. ~~Л.Одончимэг~~
6. Ч.Отгонбаяр

В заал

“Г” тойрог

1. Д.Алтанжигүүр
2. ~~Т.Алтантуяа~~
3. Л.Баатар
4. И.Ганбат
5. Х.Одбаяр

Г заал


/Энэ заалтад 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 13 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 15 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 17 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

2.4. Тухайн тойргийн бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон нөхцөлд дараах тойргоор бүрэлдэхүүнд томилох.



2.5. Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг энэ журмын 2.2-т заасан нэрсээс тойрог дотор урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-ээс шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох бөгөөд хэрэг хүлээн авсан шүүгч шүүх хуралдааныг даргална.

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.6. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн эрүүгийн хэрэг, гомдол, хүсэлт, прокурорын санал дүгнэлтийг хүлээн авсан даруй “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-д оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгч, шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.7. Шинээр томилогдсон, шилжин томилогдож ирсэн, сэлгэн ажилласан, хүндэтгэн үзэх шалтгаанаар удаан хугацаагаар /энэ журмын 3.1-д зааснаар ойлгоно/ эзгүй байсан шүүгчид прокуророос шинээр ирсэн хэрэг хуваарилах, ийнхүү хуваарилалт хийхэд нэг шүүгчид ноогдох шийдвэрлэгдээгүй байгаа дундаж хэргийн тоотой тэнцүү тооны хэрэг хуваарилах, зогсоох асуудлыг Нийтлэг журмын 1.2-т заасан зарчмыг баримтлан тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор нэмсэн/

2.8. Интернэт сүлжээний доголдол, тасалдлаас шалтгаалан “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем” ажиллаагүй үед хэргийг хуваарилахдаа гараар хуваарилахгүй ба ирсэн огнооны дарааллыг баримтлан системд нөхөн бүртгэж зөвхөн системээс хуваарилах бөгөөд энэ тохиолдолд үйлдэл тус бүрийг дүрс бичлэг хийж хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгална.

/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор нэмсэн/

2.9. Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт, прокурорын санал дүгнэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/ хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

2.10. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-ээр хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт, прокурорын санал дүгнэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

Гурав: Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах арга

3.1. Нийтлэг журмын 1 дэх хэсгийн 1.3.1-д заасан шүүхэд адил шатны шүүхээс шилжиж ирсэн эрүүгийн хэрэг /цаашид хэрэг гэх/, харьяалал тогтоолгон ирсэн хэрэг, прокуророос шилжин ирсэн хэрэг, шүүгч, нийт шүүгчдээс татгалзаж ирсэн хэрэг, дээд шатны шүүхээс шийдвэр нь хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянаж, тогтоолыг хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, нэгтгэж, тусгаарласан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт, санал, дүгнэлт мөн шүүгчийн бүрэн эрх нь дуусгавар болсон, эсхүл шүүгч удаан хугацаагаар буюу 21 ба түүнээс дээш хоногоор эзгүй байгаа тохиолдолд дахин хуваарилах хэргийг энэ журмын 2.2-т зааснаар “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-ээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлоор дараах 3 аргыг ашиглаж хуваарилна. Үүнд:

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.1.1. “Ердийн журмаар хуваарилах арга” нь бусад 2 аргаар хуваарилах хэрэгт хамаарахгүй бүх төрлийн хэрэгт хамаарна.

3.1.2. “Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга” нь 5 ба түүнээс дээш хавтастай хэрэг, 5 ба түүнээс яллагдагчтай хэргийн аль аль нь хамаарна.

3.1.3. “Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга”-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 10.6, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 22.1 дүгээр зүйл, 22.4 дүгээр зүйл, 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг тус тус хамаарна.

3.2. Прокуророос ирүүлсэн эрүүгийн хэрэг нь ачаалал тэнцүүлэх болон тодорхой төрлийн хэрэг хуваарилах нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд “ачаалал тэнцүүлэх арга”-ыг хэрэглэнэ.

3.3. Ачаалал тэнцвэржүүлэх зорилгоор Ерөнхий шүүгч түүнийг ээлжийн амралтын хугацаанд орлон ажиллах шүүгчид эрүүгийн хэргийг 01 /нэг/ тойрог алгасаж хуваарилна.

3.4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.14, 7.1, 7.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8.6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.3 дугаар зүйл /албадан ирүүлэх/, 13.1, 13.2 дугаар зүйл /гэрч, хохирогчийг хамгаалах/, 13.5, 13.7 дугаар зүйл /хамтран ажиллах этгээдээр тогтоох/, 19 дүгээр бүлэг /эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх/, 21 дүгээр бүлэг /хураан авсан хөрөнгө, орлого, эд баримтын талаар авах арга хэмжээ/ 37.5, 37.8, 37.11 дүгээр зүйлд заасан “торгох, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солих”, 44.3-т заасан болон хуулиар шүүхэд харьяалуулсан “санал, дүгнэлт, өргөдөл, гомдол, хүсэлт”-ийг энэ журмын 2.2-т заасан нэрсийн дарааллаар хуваарилна.

/Энэ заалтад 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 05 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

3.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6, 37.7, 37.9, 37.10 дугаар зүйлүүдэд заасан прокурорын дүгнэлтийг Ерөнхий шүүгч түүний эзгүйд орлон ажиллаж байгаа шүүгч хүлээн авч, хянан шийдвэрлэнэ.

3.6. Энэ журмын 3.4-д заасныг ерөнхий шүүгч, түүний эзгүйд орлон ажиллаж байгаа шүүгчид хуваарилахгүй.

3.7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.14, 37.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “... тогтоол биелүүлэх үед гарсан ямар нэг тодорхой биш зүйлийг тодруулах”, 38.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан гомдол, хүсэлт, залруулгыг тухайн хэргийг хүлээн авсан шүүгчид, эзгүй үед энэ журмын 2.2-т заасан нэрсийн дарааллаар хуваарилна.

Тайлбар: Энэ заалтад заасан “Эзгүй үед” гэдгийг тухайн асуудлыг шийдвэрлэх хуулийн хугацаанд шүүгч байхгүй байгаа тохиолдлыг ойлгоно.

3.8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан этгээдэд шийтгэл оногдуулах асуудлыг тухайн хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 06 дугаар тогтоолоор нэмсэн/

Дөрөв: Шүүгч ээлжийн амралт эдлэх үеийн хэрэг хуваарилалт

4.1. Шүүгч ээлжийн амралтаа эдэлж эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө эрүүгийн хэрэг хуваарилалтыг зогсоож, ээлжийн амралтаа эдлээд ажилд орохоос хуанлийн 07 хоногийн өмнөөс эрүүгийн хэргийг, ажилд орсон өдрөөс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол, хүсэлт, прокурорын санал, дүгнэлтийг тус тус хуваарилна.

4.2. Шүүгч ажлын шаардлагаар ээлжийн амралтын дундуур хэрэг хянан шийдвэрлэж болох ба энэ нь ээлжийн амралтын хугацааг сунгах, шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөх, хэргийг өөр шүүгчид хуваарилах үндэслэл болохгүй.

Тав: Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл

5.1. Шүүгч ээлжийн амралттай, хуанлийн 15 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдаж байгаа, хорио цээрийн дэглэмд орсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд Эрүүгийн хэрэг, өргөдөл, гомдол, санал, дүгнэлт, хүсэлтийг хуваарилахгүй.

Зургаа: Шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг өөрчлөх үндэслэл

6.1. Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөх үндэслэл болохгүй бөгөөд бүрэлдэхүүнд томилогдсон Ерөнхий шүүгч, шүүгч нь удаан хугацаагаар эзгүй байгаа, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдаж байгаа, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй тохиолдолд хурал давхцаагүй өөр шүүгчийг тойрог дотор болон өөр тойргоос санамсаргүй тохиолдлын аргаар “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-ээс томилно.

/Энэ заалтад 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 05 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6.2. Энэ журмын 6.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүх бүрэлдэхүүний шүүгчийг өөрчлөхгүй, өөр тойргийн багцаас шүүгч бүрэлдэхүүнд томилохыг хориглоно.

/Энэ заалтад 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 05 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Долоо: Эрүүгийн хэрэг дахин хуваарилалтад оруулах

7.1. Шүүгч хуанлийн 21 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдаж байгаа, хорио цээрийн дэглэмд орсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд хэргийг дахин хуваарилалтад оруулж болно.

7.2. Дараах тохиолдолд шүүгчид хуваарилагдсан хэргийг энэ журмын 3.1-д заасан аль тохирох аргаар дахин хуваарилна.

7.2.1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах татгалзлыг хангаж шийдвэрлэсэн,

7.2.2. Шүүгчийг сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилох, чөлөөлсөн, огцорсон, түдгэлзүүлсэн шийдвэр гарсан,

7.3. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шийтгэх, цагаатгах тогтоол, энэ журмын 3.4-т заасан шийдвэрийг тус тус хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүний шүүгч нарт хуваарилахгүй.

7.4. Прокурорт буцаасан болон харьяаллаар шилжүүлээд буцаж ирсэн хэргийг тухайн шүүгчид хуваарилна.

Найм: Бусад асуудал

8.1. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг хуваарилах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал тухай бүрд нь шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.

8.2. Хэрэг хуваарилалтад шүүгч, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн дур мэдэн оролцохыг хориглоно.

8.3. Нарийвчилсан журмыг “Цахим шүүх 2.0” цөм системийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем”-д тохируулахдаа шүүхийн Тамгын газрын дарга,

хэргийн хөдөлгөөний чиг үүрэг хариуцсан удирдах ажилтан, Ерөнхий шүүгчийн туслах нарын хяналтын дор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулна.

/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор нэмсэн/

8.4 Энэ журмыг зөрчсөн нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний 02 дугаар тогтоолоор өөрчилсөн/